



СТИЙЛ ПРОЕКТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ А.ГАНХУЯГ ТАНАА

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН  
ДҮГНЭЛТ

Нийслэлийн Засаг захиргааны III байр,  
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170  
Утас: (976) 7799 0101  
Цахим шуудан: [ubhd@emg.ub.gov.mn](mailto:ubhd@emg.ub.gov.mn)  
Цахим хуудас: [www.ubhealth.mn](http://www.ubhealth.mn)

2024.06.06 № 10-13-02/036/382

Зураг төсөлд эрүүл ахуйн  
хяналт хийсэн тухай

Тус байгууллагад ирүүлсэн албан хүсэлтийн дагуу Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 5.1.2 дахь заалтыг үндэслэн Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын даргын 2024 онд баталсан “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт шалгалт хийх” тухай 10-00/02 дугаартай удирдамжийн дагуу Сүхбаатар дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын авто граашны барилгын зураг төсөл, холбогдох бичиг баримтын бүрдэлд 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр эрүүл ахуйн хяналт хийлээ.

Нэг. Барилга байгууламжийн нэр:

Нийслэлийн ерөнхий архитекторын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу олгосон МЗХ2023/05-021 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар, Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газар, ерөнхий архитекторын ажлын албаны 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн загвар зурагтай.

Хоёр. Зураг төсөл боловсруулсан байгууллагын нэр:

Ерөнхий төлөвлөгөө, барилга архитектур, барилга бүтээц, барилгын дотор халаалт, агаар сэлгэлт, цэвэр бохир ус, холбоо дохиолол, гадна ус хангамж, ариутгах татуургын ажлын зураг төслийг 2024 онд Стийл Проект ХХК-д боловсруулсан./ЕГшифр:СП-А303/24.

Нэг. Барилга байгууламж барих газрын зөвшөөрөл:

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/830 дугаартай захирамжтай, 1462505907 нэгж талбарын дугаартай, Сүхбаатар дүүргийн

1550001814

16 дугаар хорооны нутаг дэвсгэрт Дамбадаржаа-2 /14061/ бүсчлэлд Төрийн захиргааны байгууллага зориулалтаар Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ /РД:6428584/-д эзэмшүүлэн олгосон эрхийн улсын бүртгэлийн Э-2203005634 гэрчилгээний дугаартай, 2038м.кв газрыг үндэслэсэн байна.

Гурав. Зураг төслийн товч агуулга:

Төлөвлөж буй барилга нь тэнхлэгээрээ 16.0м х 20.0м хэмжээтэй, зоорьгүй, 2 давхар, төмөрбетон каркасан бүтээцтэй 2 дугаар давхар нь металл каркасан бүтээцтэй барилга байхаар төлөвлөсөн байна. Үүнд:

1.Төлөвлөж буй барилгын 1 дүгээр давхар нийт 348.40м.кв талбайтай, үүнээс 296.02м.кв граж, 13.88м.кв техникийн өрөө, 32.91м.кв агуулах, 5.59 цахилгааны өрөө байхаар;

2.Төлөвлөж буй барилгын 2 дугаар давхар нийт 339.18м.кв талбайтай, үүнээс 28.76м.кв бичиг хэрэг, санхүүгийн өрөө, 71.51м.кв оффис, 26.52м.кв захирлын өрөө, 11.46м.кв нарийн бичгийн өрөө, 46.09м.кв хурлын өрөө, 25.43м.кв цайны өрөө, 18.05м.кв нягтлан менежерийн өрөө, 18.40м.кв хүний нөөц, байцаагчийн өрөө, 9.23м.кв -10.07м.кв эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөө, 6.73м.кв склад, 18.89м.кв хүлээн авах байхаар тус тус төлөвлөсөн байна.

Цэвэр ус хангамж, ариутгах татуурга: Цэвэр усаа зөөврийн буюу хэсгийн төлөвлөлттэй, 1м.куб эзэлхүүнтэй нөөцийн савтай, барилгаас гарах бохир ус нь одоо байгаа өөрийн бохир усны хоолойд холбон зайлуулагдахаар төлөвлөгдсөн.

Цахилгаан хангамж: Одоо байгаа 160 А-ын автоматаар тоноглогдсон, 0.4 кВ-ын самбараас шинээр төлөвлөж байгаа автографшны барилгыг цахилгааны эх үүсвэрээр хангана.

Дулаан хангамж: Одоо байгаа барилгын хэсгийн халаалтын системээс давхар халаалт авахаар төлөвлөсөн.

Халаалт, агаар сэлгэлт: Барилгын халаалтыг бие даасан өөрт байрлах цахилгаан тогооноос холбохоор ажлын зурагт тусгасан бөгөөд барилгын доторх агаар сэлгэлтийг ердийн болон механик системтэй байхаар ажлын зурагт төлөвлөсөн байна.

Инженер геологийн судалгааг Топ гео техник ХХК-ийн 2024 онд хийсэн судалгааны дүгнэлтэд элсэн чигжээстэй хайрган ул хөрс, хайргархаг элсэнцэр ул хөрс, шавранцар ул хөрстэй, 8 метрийн гүнтэй 6 цооногийн өрөмдлөгөөр хөрсний ус илрээгүй, олон жилийн цэвдэг ул хөрс тохиолдоогүй, газар чичирхийллийн 7 баллын бүсэд байрласан гэж дурьдсан байна.

Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг үндэслэн **ДҮГНЭХ НЬ:** Сүхбаатар дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах

Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын авто граашны барилга нэртэй барилгын ажлын зураг төсөл нь Монгол Улсын Барилгын норм ба дүрэм. Авто зогсоол БНБД 21-05-10 зураг төсөл төлөвлөлтөд заасан эрүүл ахуйн шаардлагад нийцэж байна.

Улсын ахлах байцаагчийн гаргасан эрх зүйн баримт бичиг дүгнэлтийг эс зөвшөөрвөл Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтын дагуу гомдол гаргах эрхтэй.

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Г.ЭНХМАА

ХҮЛЭЭН АВСАН:

ЗАХИРАЛ -г төлөөсөн / Г.Цэцэгчин /

(албан тушаал)



(гарын үсэг)